



ДАРХАН-УУЛ АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ



Дугаар 01-А/359

Дархан

Цагийн хязгаар тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, 66 дугаар зүйлийн 66.3, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2, 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэг, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.12 дахь заалт Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.4, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2023 оны А/419 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Аймгийн нутаг дэвсгэрт согтууруулах ундаа худалдах цагийн хязгаарыг нэгдүгээр хавсралтаар, согтууруулах ундаагаар үйлчлэх цагийн хязгаарыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Энэхүү захирамжийг Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (Л.Алтанчимэг)-д даалгасугай.

3.Энэхүү захирамж гарсантай холбоотой аймгийн Засаг даргын 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 01-А/84 дүгээр захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

4.Холбогдох хууль, тогтоомж, стандартыг хангуулж, хяналт тавьж ажиллахыг Дархан сумын Засаг дарга (Т.Тулгаа), Орхон сумын Засаг дарга (Б.Түмэнцогт), Шарын гол сумын Засаг дарга (Б.Лхамсүрэн), Хонгор сумын Засаг дарга (Т.Атархишиг), Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (П.Батсүх), Цагдаагийн газар (цагдаагийн хурандаа Д.Нацагдорж)-т тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  Б.АЗЖАРГАЛ



4524101056

Аймгийн Засаг даргын 2024 оны 08 дугаар
сарын 20-ний өдрийн 017/2024 дугаар
вахирамжийн нэгдүгээр хавсралт



АЙМГИЙН НУТАГ ДЭВСГЭРТ СОГТУУРУУЛАХ УНДАА ХУДАЙДАХ ЦАГИЙН ХЯЗГААР

Согтууруулах ундааны худалдаа	Цагийн хязгаар	
	Эхлэх цаг	Дуусах цаг
Бөөний худалдааны төв	07:00	20:00
Үйлдвэрийн нэрийн барааны дэлгүүр		
Агуулах дэлгүүр		
Бөөний төв		
Зориулалтын байртай барилгын зураг төсөл нь үйлчилгээний зориулалтаар төлөвлөгдөж тохижуулсан		
Их дэлгүүр	07:00	02:00
Хайпермаркет		
Минимаркет		
Хүнсний дэлгүүр		
Супермаркет		
Ая тухтай дэлгүүр		
24 цагаар ажиллах хуваарьтай дэлгүүр		
Нийтийн зориулалттай орон сууц, түүний орц, хонгил, суурийн давхар, өргөтгөлд байрлалтай		
Их дэлгүүр	07:00	00:00
Хайпермаркет		
Минимаркет		
Хүнсний дэлгүүр		
Супермаркет		
Ая тухтай дэлгүүр		
24 цагаар ажиллах хуваарьтай дэлгүүр		

Аймгийн Засаг даргын 2024 оны 08 дугаар сарын 10-ний өдрийн 011/59 дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт



АЙМГИЙН НУТАГ ДЭВСГЭРТ СОГТУУРУУЛАХ УНДААГААР ҮЙЛЧЛЭХ ЦАГИЙН ХЯЗГААР

Согтууруулах ундаагаар үйлчлэх үйлчилгээ	Цагийн хязгаар	
	Эхлэх цаг	Дуусах цаг
Зориулалтын байртай барилгын зураг төсөл нь үйлчилгээний зориулалтаар төлөвлөгдөж тохижуулсан		
Ресторан	11:00 14:00	22:00 02:00
Баар (паб, лоунж, караоке, диско клуб, тайчих клуб)		
Эвэнт танхимын үйлчилгээ		
Улирлын чанартай, түр сүүдрэвчтэй үйлчилгээ		
Нийтийн зориулалттай орон сууц, түүний орц, хонгил, суурийн давхар, өргөтгөлд байрлалтай		
Ресторан	11:00	22:00
Баар (паб, лоунж, караоке, диско клуб, тайчих клуб, спорт, бильярд)		
Кафе		
Бусад		

ЦАГИЙН ХЯЗААР ТОГТООХ ТУХАЙ ЗАХИРАМЖИД ХИЙСЭН НӨЛӨӨЛЛИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА

2024 оны 08 дугаар
сарын 20-ны өдөр

Дархан

1. Захиргааны хэм хэмжээний акт гаргах үндэслэл, шаардлага, зорилт

1.1. Үндэслэл:

Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2, 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэг, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.12 дахь заалт, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2023 оны А/419 дүгээр тушаал.

1.2 Шаардлага:

✓ Сүүлийн 5 жилийн тоо баримтаас харахад Дархан-Уул аймагт жилд дунджаар 681 орчим гэмт хэрэг үйлдэгдэж байгаагийн 193 буюу 28.3 хувь нь согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг эзэлж байна. 2023 оны эхний хагас жилийн байдлаар зөрчлийн хэрэг нээсэн болон хялбаршуулсан журмаар шалгасан 1425 зөрчлийн 1055 буюу 90.9 хувь согтуугаар үйлдэгджээ.

2023 оны эхний хагас жилд согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 102 бүртгэгдсэн байх бөгөөд гэмт хэрэг үйлдэгдсэн цаг хугацаагаар нь авч үзвэл 06-14 цагийн хооронд 11 гэмт хэрэг, 14-19 цагийн хооронд 19 гэмт хэрэг, 19-22 цагийн хооронд 19 гэмт хэрэг үйлдэгдсэн бол 22-06 цагийн хооронд 53 гэмт хэрэг үйлдэгдэж нийт согтуугаар үйлдэгдсэн гэмт хэргийн 52%-ийг эзэлж байна.

1.3. Зорилт:

Гэмт хэрэг зөрчлийн судалгаанд суурилан эрх ашиг, сонирхол нь хөндөгдөж буй бүлэг этгээдүүдийн саналыг үндэслэн аж ахуй нэгж байгууллагын үйл ажиллагаанд хатуу цагийн хуваарь тогтоож үйл ажиллагаанд нь саад хориг учруулалгүй хамгийн боломжит цагийн хязгаарыг тогтоох замаар Дархан-Уул аймгийн хэмжээнд архидан согтуурахтай тэмцэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг, зөрчлийн гаралтыг бууруулах, иргэдийн амар тайван амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

2. Захирамжийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

2.1. Захирамжийн ерөнхий бүтэц:

Захирамжийн нэг дэх хэсэгт “Аймгийн нутаг дэвсгэрт согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх цагийн хязгаар, интернэт кафе болон барьцаалан зээлдүүлэх үйлчилгээний газрын ажиллах цагийн хуваарь”-ийг, хоёр дахь хэсэгт Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлэхийг үүрэг болгосон, гурав дахь хэсэгт холбогдох хууль, тогтоомж, стандартыг хангуулж, хяналт тавьж ажиллахыг үүрэг болгосон.

2.2. Зохицуулж буй харилцаа нь:

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх цагийн хязгаарыг зохицуулна.

2.3. Хамрах хүрээ:

Дархан-Уул аймгийн иргэд, согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуй нэгж, байгууллага.

3. Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх бүлгийг тодорхойлох

Захиргааны ерөнхий хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсэгт заасны дагуу эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа этгээдүүдийг согтууруулах ундаагаар үйлчилдэг аж ахуй нэгж, байгууллага, иргэн гэж тодорхойлсон.

Захиргааны ерөнхий хуулийн 62 дугаар зүйлийн 62.1 дэх хэсэгт зааснаар Захиргааны хэм хэмжээний актын төслийг аймгийн Засаг даргын тамгын газрын цахим хуудсанд 2024 оны 12 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн байршуулсан.

эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх бүлгийн хүрээнд сонсох ажилагааг 2023 оны 12 дугаар сарын 21-ний өдөр зохион байгуулж энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуй нэгж байгууллагуудын 20 төлөөлөл оролцсон.

Иргэдийн санаа бодлыг тусгах зорилгоор Googleforms программ ашиглан 2024 оны 01 дүгээр сарын 04-ний өдрөөс 01 дүгээр сарын 24-ний өдрийн хооронд санал асуулга авахад 182 иргэн оролцсон.

4. Хүний эрх, эрх чөлөө, өрсөлдөөнийг хязгаарласан, эдийн засаг, нийгмийн болон бусад үйл ажиллагаанд саад хориг учруулсан, аливаа хүнд суртал, авлига гарах нөхцөл боломж бүрдүүлсэн байж болзошгүй зохицуулалт агуулж байгаа эсэх:

4.1 Иргэдийн амгалан тайван байдлыг алдагдуулах байдлаас урьдчилан сэргийлэх, тав тухтай, аюулгүй амьдрах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор нийтийн зориулалттай орон сууц, түүний орц, хонгил, суурийн давхар, өргөтгөлд байрлалтай газарт архи, согтууруулах ундаа худалдаалах цагийн хязгаарыг 07:00 цагаас 00:00 цаг хүртэл, үйлчилгээ эрхлэгчийн архи согтууруулах ундаагаар үйлчлэх цагийн хязгаарыг 11:00 цагаас 22:00 цаг хүртэл байхаар заасан. Хуульд нийцүүлэн цагийн хязгаарыг зориулалтын байртай барилгын зураг төсөл нь үйлчилгээний зориулалтаар төлөвлөгдөж тохижуулсан газраас ялгамжтай байдлаар зохицуулж өгсөн.

4.2 Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх үйл ажиллагаа эрхлэгч иргэн аж ахуй нэгжийн үйл ажиллагааг болон иргэдийн эрхийг хязгаарлахдаа аймгийн Цагдаагийн газраас гаргасан гэмт хэрэг зөрчлийн судалгаанд суурилан эрх ашиг, сонирхол нь хөндөгдөж буй бүлэг этгээдүүд дунд сонсох ажиллагааг зохион байгуулж тэдгээрийн саналыг үндэслэн аж ахуй нэгж байгууллагын үйл ажиллагаанд хатуу цагийн хуваарь тогтоож үйл ажиллагаанд нь саад хориг учруулалгүй хамгийн боломжит цагийн хязгаарыг тогтоож өгсөн. Ингэхдээ Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нийцүүлэн хязгаарласан.

4.3 Жендерийн эрх тэгш байдлыг хөндөөгүй.

4.4 Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэхгүй.

4.5 Бөөний төв, агуулах худалдаа, үйлдвэрийн нэрийн барааны дэлгүүрээс бусад дэлгүүрийн согтууруулах ундаа худалдах цагийн хязгаарыг хэт хатуу нөхцөлөөр тогтоолгүй шөнийн 02 цаг хүртэл худалдахаар тогтоож өгсөн нь гар дээрээс согтууруулах ундаа хууль бусаар худалдах үнийн хөөргөдөл бий болгох эрсдэлийг бууруулах юм.

4.6 Зах зээлд шинээр орж ирж буй аж ахуйн нэгжүүдийн хувьд бэрхшээл, хүндрэлийг бий болгохгүй.

4.7 Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсэгт зааснаар согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөл нь 2 төрлөөр олгохоор заасан. Уг хуулиар согтууруулах ундаагаар үйлчлэх цагийн хязгаарыг тусгай зөвшөөрлөөс хамааран 11:00-22:00, 14.00-04.00 цаг хүртэл байхаар тогтоосон бөгөөд Дархан-Уул аймгийн Засаг даргын захирамжаар хуульд заасан хязгаарт багтаан шөнийн тусгай зөвшөөрлөөс хамааран

22:00, 02:00 цаг хүртэл үйлчлэхээр тогтоож өгсөн тул төрийн байгууллага болон бусад иргэн, хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт ачаалал бий болгоогүй.

4.8 Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг зогсоход хүргэхгүй.

4.9 Аж ахуй нэгж, байгууллагын ажиллах цагийн хязгаарыг уян хатан байдлаар тогтоож өгсөн тул эдийн засаг, нийгмийн болон бусад үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөхгүй.

4.10 Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөхдөө хуульд заасан үндэслэлээр нөлөөлсөн.

4.11 Төрийн байгууллагаас цагийн хязгаарыг мөрдүүлж ажиллах талаар хяналт тавьж ажиллах бөгөөд хуульд нийцүүлэн боловсруулсан захиргааны хэм хэмжээний актыг мөрдүүлэх явцад хүнд суртал, авлига гарах нөхцөл байдал үүсэхгүй юм.

5. Тухайн асуудлыг зохицуулж байгаа хүчин төгөлдөр хууль, захиргааны хэм хэмжээний акт байгаа эсэх:

Тухайн асуудлыг Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулиар зохицуулсан бөгөөд ингэхдээ

Дархан-Уул аймгийн хэмжээнд тухайн асуудлыг зохицуулж байгаа хүчин төгөлдөр захиргааны хэм хэмжээний акт байхгүй.

6. Актыг хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөц, техник, эдийн засгийн тооцоо:

Холбогдох хууль, тогтоомж, стандартыг хангуулж, хяналт тавьж ажиллахыг Дархан сумын Засаг дарга /Т.Тулгаа/, Орхон сумын Засаг дарга /Б.Түмэнцогт/, Шарын гол сумын Засаг дарга /Б.Лхамсүрэн/, Хонгор сумын Засаг дарга /Т.Атархишиг/, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (П.Батсүх), Цагдаагийн газар (Д.Нацагдорж) тус тус хариуцна.

БОЛОВСРУУЛСАН: ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХЭЛТСИЙН
МЭРГЭЖИЛТЭН



Э.ХОНГОРЗУЛ

ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ҮР ДҮНГ ЗАХИРГААНЫ ХЭМ ХЭМЖЭЭНИЙ АКТАД ХЭРХЭН ТУСГАСАН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

2024 оны 08 дүгээр
сарын 20-ны өдөр

Дархан

Захиргааны ерөнхий хуулийн 32 дугаар зүйлд зааснаар захиргааны хэм хэмжээний актын төсөлд санал авах ажиллагааг 3 төрлөөр зохион байгуулж үр дүнг хуульд нийцүүлэн захиргааны хэм хэмжээний актад тусгасан. Үүнд:

Санал авах ажиллагаа 1. Захиргааны ерөнхий хуулийн 62 дугаар зүйлийн 62.1 дэх хэсэгт зааснаар Захиргааны хэм хэмжээний актын төслийг аймгийн Засаг даргын Тамгын газрын цахим хуудсанд 2024 оны 12 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн байршуулсан. Хуульд заасан 30 хоногийн хугацаанд цахим хуудсаар ямар нэг санал ирээгүй.

линк:<https://darkhan.gov.mn/wp/wp-content/uploads/2023/12/%D0%A2%D3%A9%D1%81%D3%A9%D0%BB-1.pdf>

Санал авах ажиллагаа 2. Захиргааны ерөнхий хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсэгт заасны дагуу эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа этгээдүүдийг согтууруулах ундаагаар үйлчилдэг аж ахуй нэгж, байгууллага, иргэн гэж тодорхойлсон. Сонсох ажиллагааны талаарх мэдэгдлийг эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа этгээдүүдэд орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл (DBS tv)-ээр, Дархан-Уул аймгийн Засаг даргын Тамгын газрын цахим хуудас (Дархан-Уул аймаг)-аар дамжуулж, мөн Дархан сумын Засаг даргын Тамгын газарт албан бичгээр хандаж Дархан сумын нутагт дэвсгэрт энэ төрлийн үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуй нэгж, байгууллагуудыг идэвхтэй хамруулах үүрэг чиглэл өгч ажилласан.

Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Нарийн бичгийн даргын 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдөр баталсан хөтөлбөрийн дагуу 2023 оны 12 дугаар сарын 21-ний өдөр аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын зааланд эрх, ашиг сонирхол нь хөндөгдөж буй бүлэг этгээдүүдэд зохион байгуулж 20 аж ахуй нэгж, байгууллагын төлөөлөл оролцсон.

Санал авах ажиллагаа 3. Иргэдийн санаа бодлыг тусгах зорилгоор санал асуулга авах ажиллагааг иргэдийн хамгийн өргөн хэрэглэдэг цахим платформ болох фэйсбүүкт Дархан-Уул аймгийн албан албан ёсны хуудсаар 2024 оны 01 дүгээр сарын 04-ний өдрөөс 01 дүгээр сарын 20-ны өдрийн хооронд “google form”-оор санал авч 182 иргэн оролцсон байна.

Дархан-Уул аймаг 2024 оныг “Бизнес эрхлэгчдийг дэмжих жил” болгон зарласантай холбоотой бүхий л талаар бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжих


бодлогын баримтлан аж ахуй нэгж, байгууллагатай хийсэн хэлэлцүүлэг, санал асуулгын үр дүнг хуулийн хүрээнд тусгаж хэм хэмжээний актыг боловсруулсан.

Үр дүнг захиргааны хэм хэмжээний актад тугасан байдал

Согтууруулах ундааны худалдаа	Хэлэлцүүлгийн үр дүн		Санал асуулгын үр дүн		Хэм хэмжээний актад туссан байдал	
	Эхлэх цаг	Дуусах цаг	Эхлэх цаг	Дуусах цаг	Эхлэх цаг	Дуусах цаг
Бөөний худалдааны төв	07:00	20:00	07:00	22:00	07:00	20:00
Үйлдвэрийн нэрийн барааны дэлгүүр						
Агуулах дэлгүүр						
Бөөний төв						
Зориулалтын байртай барилгын зураг төсөл нь үйлчилгээний зориулалтаар төлөвлөгдөж тохижуулсан						
Их дэлгүүр	07:00	02:00	07:00	23:00	07:00	02:00
Хайпермаркет						
Минимаркет						
Хүнсний дэлгүүр			07:00	00:00		
Супермаркет						
Ая тухтай дэлгүүр						
24 цагаар ажиллах хуваарьтай дэлгүүр						
Нийтийн зориулалттай орон сууц, түүний орц, хонгил, суурийн давхар, өргөтгөлд байрлалтай						
Их дэлгүүр	07:00	00:00	07:00	00:00	07:00	00:00
Хайпермаркет						
Минимаркет						
Хүнсний дэлгүүр						
Супермаркет						
Ая тухтай дэлгүүр						
24 цагаар ажиллах хуваарьтай дэлгүүр						

Согтууруулах ундаагаар үйлчлэх үйлчилгээ	Хэлэлцүүлгийн үр дүн		Санал асуулгын үр дүн		Хэм хэмжээний актад туссан байдал	
	Эхлэх цаг	Дуусах цаг	Эхлэх цаг	Дуусах цаг	Эхлэх цаг	Дуусах цаг
Зориулалтын байртай барилгын зураг төсөл нь үйлчилгээний зориулалтаар төлөвлөгдөж тохижуулсан						
Ресторан	11:00	22:00	11:00	22:00	11:00	22:00
Баар (паб, лоунж, караоке, диско клуб, тайчих клуб)						
Эвэнт танхимын үйлчилгээ						
Улирлын чанартай, түр сүүдрэвчтэй үйлчилгээ						
Нийтийн зориулалттай орон сууц, түүний орц, хонгил, суурийн давхар, өргөтгөлд байрлалтай						
Ресторан	11:00	00:00	11:00	21:00	11:00	22:00
Баар (паб, лоунж, караоке, диско клуб, тайчих клуб, спорт, бильярд)						
Кафе						
Бусад						


МЭДЭЭЛЭЛ БЭЛТГЭСЭН: ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХЭЛТСИЙН
МЭРГЭЖИЛТЭН


 Э.ХОНГОРЗУЛ

Санал авах ажиллагаа 2. Үр дүн


Нас

182 responses




Хүйс

182 responses




Цагийн хязгаар тогтоохыг дэмжиж байгаа эсэх

179 responses



Их дэлгүүр, Хайпермаркет, Минимаркет, Хүнсний дэлгүүр, Супермаркет, Ая тухтай дэлгүүрийн архи, согтууруулах ундаа худалдах цагийн хязгаар
182 responses




24 цагаар ажиллах хуваарьтай дэлгүүрийн архи, согтууруулах ундаа худалдах цагийн хязгаар
182 responses



Бөөний худалдааны төв, үйлдвэрийн нэрийн барааны дэлгүүр, агуулах дэлгүүр, бөөний төвийн архи, согтууруулах ундаа худалдах цагийн хязгаар
182 responses



Зориулалтын байртай барилгын зураг төсөл нь үйлчилгээний зориулалтаар төлөвлөгдөж тохижуулсан Ресторан, Баар (паб, лоунж, карао...согтууруулах ундаагаар үйлчлэх цагийн хязгаар
182 responses



Нийтийн зориулалттай орон сууц, түүний орц, хонгил, суурийн давхар, өргөтгөлд байрлалтай Ресторан, Баар (паб, лоунж, караоке, диско клу...согтууруулах ундаагаар үйлчлэх цагийн хязгаар
182 responses



Кафе, Баар (бильярд) архи согтууруулах ундаагаар үйлчлэх цагийн хязгаар
182 responses

